



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16  
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

АЙМАГ НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ГАЗАР, БОЭТ, ЭМЯ-НЫ ХАРЬЯА  
ТӨВ ЭМНЭЛЭГ, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН  
ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВҮҮДИЙН  
ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

2020.11.11 № 18/4857  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Коронавируст халдвар, “Ковид – 19”-ийн  
цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн  
байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд  
**Тодотгол** хийж ирүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/418 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны “Коронавируст халдвар, Ковид-19”-ийн цар тахлын хариу арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар хүргүүлж байна.

Төлөвлөгөөний дагуу өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллага тус бүрийн “Коронавируст халдвар, Ковид 19”-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө”-нд тодотгол хийлгэн баталгаажуулж, байгууллага тус бүрээр нь нэгтгэн цаасаар болон цахим (Able) - аар (“pdf” форматаар) 2020 оны 11 дүгээр сарын 17-ны дотор яаралтай ирүүлнэ үү.

Хавсралт 8 хуудастай.

Жич: “Коронавируст халдвар, Ковид-19”-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн үнэлгээний тайлан ирүүлээгүй байгаа Баян-Өлгий, Дундговь, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий аймгууд яаралтай ирүүлэхийг мэдэгдье.

ДЭД САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН УЛСЫН  
АЛБА - ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН  
ТОГТОЛЦООНЫ ДАРГЫН ОРЛОГЧ



Ш.АНХМАА

144209812



БАТЛАВ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН УЛСЫН АЛБА- ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН  
ТОГТОЛЦООНЫ ДАРГА  
Т.МӨНХСАЙХАН

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР, КОВИД-19- ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН УЛСЫН АЛБА-ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН  
ТОГТОЛЦООНЫ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр

Д.Д	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах баг, албан тушаалтан, хамтран ажиллах байгууллага	Хүрэх түвшин
<b>1.ТАНДАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>				
1	Эрсдэлийн үнэлгээ хийх, үнэлгээний дүнг шийдвэр гаргах үйл ажиллагаанд тухай бүрт тусган хэрэгжүүлэх	Тухай бүрт	Эрсдэлийн үнэлгээний баг	Тухай бүрт эрсдэлийн үнэлгээ хийгдэж, хариу арга хэмжээний чиглэл тодорхойлогдсон байна.
2	Улсын Онцгой комиссын дэргэдэх "Шуурхай штаб"-т ЭМЯ-наас ажиллах бүрэлдэхүүнийг томилон ажиллуулах	2020 оны 11 дүгээр сарын 11-нд	Эрүүл мэндийн Улсын алба (ЭМУА)-ны Тохiolдлын удирдлагын тогтолцоо (ТУТ)-ны менежер	Ажиллах бүрэлдэхүүн Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдаж, Шуурхай штабт ажиллаж эхэлсэн байна.
3	Үүссэн нөхцөл байдал, сэжигтэй болон халдвартай тохиолдлын талаар ХӨСҮТ- өөс яаралтай мэдээлэх, голомтын хүрээ тогтоох, хамгаалалтад авах	тухай бүр	ХӨСҮТ, УОК-ийн шуурхай штаб, Тандалтын баг	Мэдээлэл яаралтай шуурхай дамжиж, голомтын хүрээг тогтоон хамгаалалтад авсан байна.
4	Халдварын голомтыг цомхотгох тандалт судалгаа хийх, эрэн сурвалжлах үйл ажиллагаа зохион байгуулах	2020 оны 11 дүгээр сарын 11-ээс	ЭМЯ-ны тандалтын баг, УОК -ын шуурхай штаб	Яаралтай хариу арга хэмжээ авах голомтын зураглал бүрэн гарсан байна



5	Аймгуудтай цахимаар холбогдож хавьтлын тандалт хийх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх	2020 оны 11 дүгээр сарын 11-ээс, тогтмол	ЭМУА-ТУТ- ны штаб, Тандалтын баг, ЭХХБ	Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан бүх аймгуудад хавьтлын тандалт судалгаа хийх мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөгдсөн байна.
6	Халдварын дэгдэлт, цар тахлын үед нийслэл, дүүргийн хэмжээнд хөдөлгөөн хязгаарлах, хорио цээрийн дэглэм тогтоох санал боловсруулж шийдвэрлүүлэх	тухай бүр	Тандалтын баг, ХӨСҮТ	Саналын дагуу хэсэгчлэн болон бүрэн хөл хорио тогтоох шийдвэр гарч хэрэгжиж эхэлсэн байна.
7	Тусгаарлалтаас болон эмнэлэгт эмчлэгдэн гарсан иргэдийг бүртгэлжүүлэн халдварын тандалт, хяналтын тасралтгүй байдлыг хангах	Тогтмол	Тандалтын баг, аймаг, нийслэлийн ЭМГ	Сэжигтэй болон халдвартай тохиолдлыг баталгаажуулах үйл ажиллагаа сайжирсан байна.
8	Коронавируст халдвар, Ковид 19-ийн цар тахлын үед эрүүл мэндийн салбараас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, нөхцөл байдлын талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудад шуурхай хүргэх	Тухай бүрт	ЭМУА-ТУТ-ны штаб, Эрсдэлийн харилцаа холбооны баг, Тандалтын баг	Мэдээлэл тухай бүрт шуурхай хүргэгдэж хариу арга хэмжээний шийдвэрийг цаг алдалгүй хэрэгжүүлсэн байна.
9	Ундны усны төвлөрсөн хангамж, усан сан, ундны болон зөөврийн ус тээвэрлэх, түгээх үйл ажиллагааны эрүүл ахуй, аюулгүй байдал, хангамжийн тасралтгүй байдлыг хангах	Тогтмол	Тандалтын баг, ЭМЯ-ны НЭМГ, бусад холбогдох байгууллага	Ундны усны төвлөрсөн хангамж, усан сан, ундны болон зөөврийн ус тээвэрлэх, түгээх үйл ажиллагааны эрүүл ахуй, аюулгүй байдал бүрэн хангагдсан байна.
<b>2.ЭРСДЛИЙН ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>				
10	Иргэдэд Коронавируст халдвар, Ковид -19-ийн талаарх нөхцөл байдлын талаар "нэг сувгаар" үнэн, зөв мэдээлэл түгээх	Тогтмол	Эрсдэлийн харилцаа холбооны баг	Иргэдэд Коронавируст халдвар, Ковид- 19-ийн талаарх нөхцөл байдлын талаар үнэн, зөв мэдээлэл цаг алдалгүй тухай бүрт хүргэгдсэн байна.
11	Коронавируст халдвар, Ковид - 19-ийн талаар иргэдэд зориулсан сэрэмжлүүлэг, мэдээлэл, сурталчилгаа зохион байгуулах	Тогтмол	Эрсдэлийн харилцаа холбооны баг, НЭМҮТ	Иргэдэд зориулсан сэрэмжлүүлэг, мэдээлэл, сургалт сурталчилгаа тасралтгүй, тогтмол зохион байгуулагдсан байна.



12	Иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх байнгын үйл ажиллагаатай Тусгай утас (119, 1800-0119) ажиллуулах	Тогтмол	ЭХХБ, НЭМҮТ, ЭМХТ	Иргэд чирэгдэлгүйгээр эрүүл мэндийн үйлчилгээ зөвлөгөөг шуурхай авах нөхцөл бүрдэнэ.
13	Эрсдэлт бүлгийн хүн амын тоо, мэдээллийг 14 хоног тутамд авч, нэгтгэн холбогдох байгууллагад мэдээлэх	тухай бүр	ЭХХБ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Мэдээлэл нэгтгэгдэн УОК-т хүргэгдсэн байна.
<b>3. ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>				
14	Коронавируст халдвар, Ковид-19-ийн нөхцөл байдалтай уялдуулан ЭМУА-ТУТ-ны арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийх	Эрсдлийн үнэлгээний дүн хүлээх авснаас 24 цагийн дотор	ЭМУА-ТУТ-ны штаб, Төлөвлөлт, хяналтын баг,	Нөхцөл байдалтай уялдуулан ТУТ-ны арга хэмжээний төлөвлөгөөнд тухай бүрт тодотгол хийж баталгаажуулан эрүүл мэндийн байгууллагуудад шуурхай хүргэгдсэн байна.
15	Халдварын тусгаарлах, ажиглах үйл ажиллагаанд хяналт - үнэлгээ хийх	тухай бүр	Төлөвлөлт хяналтын баг, ЭМЯ-ны ХШУДАГ, МХЕГ, ажлын хэсэг	Хяналт- үнэлгээ хийгдэж зөвлөмж гарсан байна.
16	Хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалтын байдалд хамтарсан хяналт - үнэлгээ хийх	тухай бүр	Төлөвлөлт хяналтын баг, ХШУДАГ, бусад холбогдох байгууллага	Хяналт үнэлгээ хийгдэж зөвлөмж гарсан байна.
17	Нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих	тухай бүр	Нөөцийн бэлэн байдал, хангалтын баг, ХШУДАГ, бусад холбогдох байгууллага	Хяналт хийгдэж зөвлөмж гарсан байна.
18	Цахим мэдээллийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих (butgel.mn)	тухай бүр	Төлөвлөлт хяналтын баг, ХШУДАГ, ЭМЦМХ, бусад холбогдох байгууллага	Хяналт хийгдэж зөвлөмж гарсан байна.
19	Эрүүл мэндийн ажилтнуудыг эрсдэлээс хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудад өгөгдсөн зөвлөмж, Эрүүл мэндийн сайдын албан тоот, Эмнести Интернэшнл байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх	тухай бүр	Төлөвлөлт хяналтын баг, ХШУДАГ, бусад холбогдох байгууллага	Үнэлгээ хийгдэж, үнэлгээтэй холбоотой арга хэмжээ авагдсан байна.



20	Шаардлагатай тохиолдолд олон улсын байгууллагын дэмжлэг тусалцаа авах	тухай бүр	ЭМЯ-ны ТЗУГ-ГХАХ, Олон улсын байгууллага	Олон улсын байгууллагатай хамтран ажиллаж шаардлагатай дэмжлэг тусалцаа авсан байна.
<b>4. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ</b>				
21	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд КОВИД-19-ийн халдварын үед ажиллах тусгайлсан төлөвлөгөө гаргаж, эрэмбэлэн ангилах, яаралтай тусламжийн урсгал зохицуулалт хийсэн байх	тухай бүр	Хариу арга хэмжээний баг (ХАХБ), Хүний нөөцийн бэлэн байдал, хангалт, сургалтын баг (ХНББХСБ), НЭМГ, Аймгийн ЭМГ	Заавар, зөвлөмж гарч, мэргэжил арга зүйн удирдлагаар хангагдсан байна.
22	Тусгаарлах, ажиглах байранд байгаа хүнийг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх зураглалыг шинэчлэх, боловсронгуй болгох	11 сарын 11-ээс	Хариу арга хэмжээний баг	Зураглал шинэчлэгдэн эрүүл мэндийн байгуулагуудад хүргэгдсэн байна.
23	Өвчтөн хүлээн авах яаралтай тусламжийн урсгалд зохицуулалт хийх	тухай бүр	Хариу арга хэмжээний баг, НЭМГ, Түргэн тусламжийн төв	Заавар, зөвлөмж гарч, мэргэжил арга зүйн удирдлагаар хангагдсан байна.
24	Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II -ийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ор дэлгэх, бэлэн байдлыг хангах тусгайлсан төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	11 сарын 11-ээс	ХАХБ, Санхүү хөрөнгө оруулалтын баг (СХОБ), Нөөцийн бэлэн байдал, хангалтын баг (НББХБ)	Төлөвлөгөө батлагдан хэрэгжиж эхэлсэн байна.
25	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг хүлээн авах, тусгаарлах, эмчлэх үйл ажиллагааг зохион байгуулах	11 сарын 11-ээс	Аймаг, нийслэлийн ЭМГ, ЭМБ	Эмнэлгүүд халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг хүлээн авч, тусгаарлан эмчилж эхэлсэн байна.
26	Дүүргүүдэд халдвар илрүүлэх, түргэвчилсэн шинжилгээ хийх "Шинжилгээний цэг" байгуулах	11 сарын 11-ээс	ХАХБ, НББХБ, НЭМГ, ЭМБ	Цэгүүд байгуулагдаж шинжилгээ хийгдэж эхэлсэн байна.
27	Батлагдсан тохиолдлын хавьтлыг тусгаарлаж шинжилгээнд хамруулах	Тогтмол	Аймаг, нийслэлийн ЭМГ	Хавьтлын шинжилгээг тухай бүрт тогтмол хийж хэвшсэн байна.



28	Халдварын голомтод эцсийн ариутгал, халдваргүйтгэл хийх	тогтмол	ЗӨСҮТ, НЭМГ, бусад салбарын холбогдох байгууллагууд	Халдварын голомтын эцсийн ариутгал халдваргүйтгэл тогтмол хийгдэж хэвшсэн байна.
29	Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай эмнэлгийн ор нэмэлтээр дэлгэх, хүний нөөц, тоног төхөөрөмж, хэрэгслийг дайчлан ажиллуулах	тухай бүр	НББХБ, ХАХБ, ХНББХСБ, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага	Шаардлагатай нөөцийг нэмэлтээр дайчлан ажилуулж тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангасан байна.
30	Цар тахлын үед хээрийн эмнэлэг дэлгэн ажиллуулах журам боловсруулан батлуулах	2020 оны 11 сард	ХАХБ	Журмын санал УОК-т хүргэгдэж, журам Шадар сайдаар батлагдсан байна.
31	Үйлчлүүлэгч тусламж, үйлчилгээ авах үедээ эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар авахаас сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах	тогтмол	Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллага	Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар тархах эрсдэлийг бүрэн хязгаарласан байна.
32	Коронавируст (КОВИД-19) халдварын цар тахлын үед иргэдэд үзүүлэх эмнэлгийн бусад тусламж, үйлчилгээний хэвийн тасралтгүй ажиллагааг хангах	тогтмол	Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллага	Коронавируст (КОВИД-19) халдвартай холбоогүй эмнэлгийн бусад тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал хангагдсан байна.
33	Цар тахлын улмаас хөл хорио болон тусгаарлалтад байгаа эмзэг бүлгийн иргэд тухайлбал, асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настнуудад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх	тогтмол	СЭМҮТ, Эрүүл мэндийн байгууллага	Эмзэг бүлгийн иргэд сэтгэл зүйн зөвлөгөө дэмжлэг авсан байна.
34	Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах үйл ажиллагааг цахммаар гүйцэтгэх	тухай бүр	ХНХЯ-ны Хөдөлмөрийн чадвар алдалтын төв комисс, нэгдсэн эмнэлэг	ХЧА-ыг тогтоох сунгах үйл ажиллагааг цахимаар (цахим хурал, зөвлөгөөн) гүйцэтгэсэн байна.
<b>5. НӨӨЦИЙН БЭЛЭН БАЙДАЛ</b>				
35	Эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, тоног, төхөөрөмж, лабораторийн урвалж оношлуур, ариутгал, халдваргүйтгэлийн нөөц, зарцуулалтад хяналт тавих, нөхөн сэлбэх, хуваарилах тасралтгүй байдлыг хангах	тогтмол	НББХБ, СХОБ, ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар	Нөөцийн байнгын бэлэн байдал бүрэн хангагдсан байна.



36	Нөөцийн тэгш хуваарилалт, иргэдэд эм, эмнэлгийн хэрэгслийн зохиомол хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлж зарим эм, эмнэлгийн хэрэгслийн борлуулалтад "хязгаарлалт" тогтоох арга хэмжээг хэрэгжүүлэх, санал боловсруулах шийдвэрлүүлэх	шаардлагатай тохиолдолд	НББХБ, СХОБ	Хязгаарлалт тогтоох талаарх санал шийдвэрлэгдсэн байна.
37	Дайчлан ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудыг хувийн хамгаалах хэрэгслээр хангах, шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгслээр үйлчлэх	тухай бүр	Аймаг, нийслэлийн ЭМГ, ЭМБ	Шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслээр тасралтгүй хангах нөөцийг бүрэн бүрдүүлсэн байна.
<b>6. ХҮНИЙ НӨӨЦИЙН БЭЛЭН БАЙДАЛ, ХАНГАЛТ, СУРГАЛТЫН ЗОХИЦУУЛАЛТ</b>				
38	Тусгаарлан ажиглах байранд ажиллах резидент эмчийн судалгааг шинэчлэн гаргах	2020 оны 11 дүгээр сарын 13, тухай бүрт	ЭМХТ, Сургалт эрхлэх байгууллагууд	Тусгаарлан ажиглах байранд ажиллах резидент эмч нарын нэр, хаяг, холбоо барих утас зэрэг мэдээлэл шинэчлэгдсэн байна.
39	Дайчлагдан ажиллах эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, мэдээгүйжүүлгийн болон бусад тасагт ажиллах эмч, сувилагчийн ажиглах хуваарийг шинэчлэн гаргах, бэлэн байдлыг хангах	2020 оны 11 дүгээр сарын 13, тухай бүрт	ХНББХСБ, ЭМХТ	Дайчлагдан ажиллах эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, мэдээгүйжүүлгийн болон бусад тасагт ажиллах ажиглаж буй эмч, сувилагчийн хуваарь тодорхой болсон байна.
40	Тэтгэвэрт гарсан эмч, эмнэлгийн мэргэжилтний судалгааны дагуу дайчлан ажиллах нөөцийг шинэчлэх	тухай бүр	ХНББХСБ, ЭМХТ	Тэтгэвэрт гарсан эмч, сувилагчийн байршил, холбогдох утас, нэр тодорхой болсон байна.
41	Ковид 19 халдварын голомтод ажиллах хүний нөөцийн талаар мэдээллийг үндэсний хэмжээнд нэгтгэх, тодруулга хийх	2020 оны 11 дүгээр сарын 13, тухай бүр	ХНББХСБ, ЭМХТ,	Хүний нөөцийн шаардлагатай мэдээ, мэдээлэлд тухай бүртээ тодруулга хийгдэж шинэчлэгдэн бэлэн байдлыг хангасан байна.



42	Эрүүл мэндийн ажилтнуудад ажлын байран дээр нь халдвараас сэргийлэх халдварын үед баримтлах халдвар хамгааллын дэглэм, үзүүлэх тусламж үйлчилгээ, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ Г.М сэдвээр дадлага сургуулилт, цахим сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа зохион байгуулах	тогтмол	ЭМХТ, Эрүүл мэндийн байгууллагууд	Батлагдсан удирдамжийн дагуу тодорхой сэдвээр (гар угаах, хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэх, орчны халдваргүйтгэл гэх мэт) эрүүл мэндийн байгууллагын 54000 гаруй ажилтан хамрагдсан байна.
43	2021 оны шинэ элсэлтийн резидент эмч, төгсөх дамжааны оюутнуудыг халдварын хяналт, КОВИД-19 цар тахлын халдвар, томуу, томуу тест өвчний сэргийлэлт, хяналтын чиглэлээр сургалтад хамруулах	тухай бүр	ЭМХТ, Сургалт эрхлэх байгууллагууд	2021-2022 оны хичээлийн жилд үндсэн мэргэшлийн сургалтад элссэн резидент эмч, төгсөх дамжааны оюутнууд бүрэн хамрагдсан байна.
44	КОВИД-19 цар тахлын үед тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн мэргэжилтнийг сэлгэн ажиллуулах төлөвлөгөөнд тодруулга хийх	2020 оны 11 дүгээр сарын 13, тухай бүрт	ЭМХТ, ХӨСҮТ, Аймаг нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Халдварын үеийн нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөгөөнд тухай бүрт тодруулга хийгдсэн байна.
<b>7. САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>				
45	Голомтыг цомхотгох, хариу арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоог нэгтгэн гаргах, шаардагдах төсвийг батлуулах, хуваарилах	тухай бүр	СХОБ, Бүх багууд	Төсөв батлагдаж, гаардлагатай үйл ажиллагаа, байгууллагуудад хуваарилагдсан байна.
46	Дайчлагдан ажиллаж байгаа эмч, ажиллагчидын илүү цагийн хөлс резидент эмчийн урамшууллын хэмжээг тооцож, шаардагатай төсөв батлуулах	тухай бүр	Санхүү хөрөнгө оруулалтын баг, Хүний нөөцийн бэлэн байдал, хангалт, сургалтын баг	Төсөв батлагдаж эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай санхүүжилт хуваарилагдсан байна.
47	КОВИД-ын эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулахад шаардагдах вакцины төсвийн тооцоог хийж төсвийн тодотголоор нэмэлтээр батлуулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах	тухай бүр	Тандалтын баг	Дархлаажуулах үйл ажиллагааны санхүүжилт бүрэн шийдэгдэж, вакцин худалдан авсан байна.



48	Шардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, лабораторийн урвалж, оношлуур, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисын нөөц бүрдүүлэх төсвийг тооцож, нэмэлтээр батлуулах, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах	тухай бүр	Нөөцийн бэлэн байдал, хангалтын баг, Үнэлгээний хороо	Хуваарийн дагуу нөөцийн хуваарилалт хийгдсэн байна.
49	Аймаг, нийслэлийн эмнэлгүүдэд нийлүүлэгдэх 16 багц бүхий тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, хуваарилах	2020 оны 11 дүгээр сарын 11-ээс	Нөөцийн бэлэн байдал, хангалтын баг	21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт хуваарилалт хийгдэж түгээгдсэн байна.
50	Тоног төхөөрөмж, түргэн тусламжийн машин, хувийн хамгаалах хэрэгсэлийг нийлүүлэх 15 багц бүхий худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, хуваарилах	2020 оны 11 дүгээр сарын 11-ээс	Нөөцийн бэлэн байдал, хангалтын баг	Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж, хуваарилалт хийгдэж түгээгдсэн байна.
51	ХӨСҮТ-ийн биоаюулгүй байдлын 3 дугаар зэргийн лаборатори ашиглалтад оруулах	2020 оны 11 дүгээр сарын 11 сард	ХӨСҮТ, ЭЗСХОГ-ХОХ	ХӨСҮТ-ийн биоаюулгүй ажиллагааны 3 дугаар зэргийн лаборатори үйл ажиллагаагаа эхэлсэн байна.
52	ХӨСҮТ-ийн орны тоог нэмэгдүүлэх	2020 оны 11 дүгээр сарын 11-нээс	ХӨСҮТ	Тусламж үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.